

“ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2014 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Зоригт**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг чуулганы 2014 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийллээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлэг, Ардчилсан намын бүлэг, “Шударга ёс эвсэл”-ийн бүлэг, төр, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас давхардсан тоогоор нийт 170 гаруй санал ирүүлснийг хянан үзээд, Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлд шууд заасан арга хэмжээнүүдийг хавсралтаар батлах, уг хавсралтад тусгах арга хэмжээг гадаад валютын урсгалыг сайжруулах, санхүү, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, хөгжлийн бодлого, хөгжлийн зээл, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, төрийн өмчийн удирдлагын тогтолцоог шинэчлэх гэсэн дөрвөн чиглэлээр өөрчлөх, мөн тогтоолын төслийн нэрийг “эдийн засгийг идэвхжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэж өөрчлөх зарчмын саналуудыг Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү, М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан нар гаргасныг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн дээрх гишүүдээс гаргасан дараах саналуудыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд эдгээр саналыг тоймлон авч үзвэл:

Төсвийн урсгал зардлыг бууруулж, хэмнэлтийн горимд шилжих, улсын төсөвт ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн тооцох, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахгүй байх чиглэлээр Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх, уул уурхайн салбарын эрх зүйн орчныг

тогтвортой болгох, төр хайгуул, олборполтын үйл ажиллагаанд оролцохыг хязгаарлах, эрдэс баялгийн бодлогын зөвлөлийг байгуулах, ашигт малтмалын хайгуулын ажлыг сэргээх чиглэлээр Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах, Таван толгойн талаар Улсын Их Хурлаас баталсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Таван толгойн орд газраас олборлож байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулан, нэмүү өртөг шингээж, экспортын нэг цонхны бодлогын хүрээнд олон улсын зах зээлд борлуулах, уг зорилгоор орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байх хувилбараар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор шийдвэрлэх, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд Оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг түргэтгэх, уг төслийн хэрэгжилтэд Улсын Их Хурал, Засгийн газраас бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах, Таван толгой-Гашуунсухайт-Нарийнсухайт-Шивээхүрэнгийн төмөр зам болон тээврийн бусад дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар барьж байгуулах, төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, тусгай зөвшөөрлийн тоог эрс цөөлөх чиглэлээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх зэрэг саналуудыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Бичил, жижиг, дунд бизнесийн хөгжлийн санхүүжилтийн арга хэлбэрүүдийг боловсронгуй болгох чиглэлээр Засгийн газар, Монголбанкны үйл ажиллагааг уялдуулах, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсч, валютын заход цочрол бий болсон үед түүний нөлөөллийг саармагжуулах арга хэмжээг цаг тухайд нь авч байх, санхүү, эдийн засгийн болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх зорилгоор гадаад валютын урсгалыг сайжруулах, валютын ханшийн эрсдэлийг бууруулах санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэрэглээг бүх чиглэлд идэвхжүүлэх зэрэг 8 багц саналыг өргөн мэдүүлсэн тогтоолын төслөөс хасах саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийж 2014 оны 6 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулан цаашид уг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх, Монгол Улсын нэгдсэн төсвөөс гадуур хяналтгүй зарцуулагдаж байгаа Чингис болон Самурай бонд, Хөгжлийн банкны зээлийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн төсөвт тусгах, бага, дунд орлоготой иргэдэд хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх, Чингис бондын хуваарилагдаагүй болон зарцуулагдаагүй хөрөнгийн эх үүсвэрийг бодитой үйлдвэрлэлд хөрөнгө оруулах буюу үйл ажиллагаа нь жигдэrsэн экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг саналууд олонхиын дэмжлэг аваагүй бөгөөд эдгээр 6 санал дээр Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан нар цөөнх болсон.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар төсвийн хөрөнгийн урсгал зардлыг 20 хувиар бууруулах, төрийн байгууллага, албан тушаалтан баяр, ойн арга хэмжээ, дайллага, хүлээн авалт, бэлэг дурсгалд төсвийн хөрөнгөөс гаргахыг хориглох, Төсвийн хөрөнгөөр хэвлэл, мэдээлэлд сурталчилгаа хийх, хаалтын гэрээ хийхийг хориглох саналууд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадсангүй. Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар төсвийн хөрөнгийн урсгал зардлыг 20 хувиар бууруулах санал дээр цөөнх болохоо илэрхийлсэн болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг төр ба хувийн хэвшлийн эрх үүргийн тэнцвэр, санхүүжилт, төлбөр, тооцооны хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, ядуурлын олон хүчин зүйлээс хамааралт байдал, архаг шинж чанартай болж байгаад дүгнэлт хийж, Өрхийн амьжиргааг дэмжих үндэсний хөтөлбөрт тэтгэвэр, тэтгэмж, хalamжийн тогтолцонд олон улсын туршлагын дагуу нөхцөлт мөнгөн шилжүүлэгийн зарчим, арга хэрэгслийг нэвтрүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах, цалингийн болон тэтгэврийн зээлийн нөхцөлүүдийг хүртээмжтэй санхүүжилтийн зарчмаар зөвлрүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинд сөрөгөөр нөлөөлөхгүй байх чиглэлээр Засгийн газар, Монголбанк хамтран ажиллах арилжааны банкуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлээс гаргасан саналууд олонхын дэмжлэг аваагүй болно.

“Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн Та бүхэнд тараасан.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ГАРАМГАЙБААТАР



Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

**“ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Байнгын хорооны дэмжсэн санал:

1. Тогтоолын төслийн нэрийг “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

2. Тогтоолын төслийн 1 дэх заалтад заасан арга хэмжээнүүдийг “Нэг.Гадаад валютын урсгалыг сайжруулах, санхүү, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэх хүрээнд”, “Хоёр. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих хүрээнд”, “Гурав.Хөгжлийн бодлого, хөгжлийн зээл, санхүүжилтийн хүрээнд”, “Дөрөв.Төрийн өмчийн удирдлагын тогтолцоог шинэчлэх хүрээнд” гэсэн 4 хэсэг бүхий “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл” гэсэн хавсралтаар батлах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

3. Тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын” гэсний өмнө “эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

4. Тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2. Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэлд заасан арга хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулганы хугацаанд багтаан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, Монголбанк /Н.Золжаргал/-нд, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус үүрэг болгосугай.”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

5. Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.” Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

6. Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3. Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллах, холбогдох хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг 2014 оны 06 дугаар сарын 01-ний дотор багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

7. Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг хавсралтын 1.2 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого баталсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах болон ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг сэргээхтэй холбогдох хуулийн төслийг доор дурдсан чиглэлээр боловсруулж, өргөн мэдүүлэх:

- уул уурхайн салбарын эрх зүйн орчныг тогтвортой болгох;
- төр хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцохыг хязгаарлах;
- эрдэс баялгийн бодлогын зөвлөлийг байгуулах;
- ашигт малтмалын хайгуулын ажлыг сэргээх.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

8. Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг хавсралтын 2.1 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын татварын ачааллыг бууруулж, тайлагнах журмыг хөнгөвчлөх, ил тод, нээлттэй болгох, зарим татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр татварын багц хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

9. Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хавсралтын 4.1 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Төрийн өмчийн хороо болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын тогтолцоог шинэчлэх, засаглалын бие даасан байдлыг хангах, үйл ажиллагааг бизнесийн зарчимд бүрэн нийцүүлэх, Засгийн газраас төрийн өмчит компанийт зөвхөн татвар ногдуулах, ногдол ашиг хуваарилах сувгаар харилцдаг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл, Ц.Нямдорж
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

10.Тогтоолын төслийн 1.4 дэх дэд заалтыг хавсралтын 2.5 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Үндэсний үйлдвэр, дотоодын аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагааны өртөг, зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн нэлөөллийг саармагжуулах, зээл, зээлийн даатгалд хамруулах болон гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд оролцоход нь дэмжлэг үзүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

11.Тогтоолын төслийн 1.5 дахь дэд заалтыг хавсралтын 1.9 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Хөрөнгө оруулалтын сангудыг бий болгох, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг идэвхжүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

12.Тогтоолын төслийн 1.6 дахь дэд заалтыг хавсралтын 3.3 дахь дэд заалт болгон “өргөжүүлж” гэсний дараа “засаглалыг сайжруулах” гэж, “тухай” гэсний дараа “болон холбогдох бусад” гэж тус тус нэмэх, “нэмэгдүүлэх,” гэсний дараах “Хөгжлийн банкнаас хийж байгаа “гэснийг, “тухай” гэсний дараах “хуульд” гэснийг тус тус хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

13.Тогтоолын төслийн 1.7 дахь дэд заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

14.Тогтоолын төслийн 1.8 дахь дэд заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

15. Тогтоолын төслийн 1.9 дэх дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

16. Тогтоолын төслийн 1.10 дахь дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

17. Тогтоолын төслийн 1.11 дэх дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

18. Тогтоолын төслийн 1.12 дахь дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

19. Тогтоолын төслийн 1.13 дахь дэд заалтыг хавсралтын 3.1 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Олон улсын зах зээлд арилжаалсан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, хяналтыг сайжруулах, хөгжлийн зээл, санхүүжилт, улсын өрийн зохистой удирдлагын хүрээнд Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

20. Тогтоолын төслийн 1.14 дэх дэд заалтыг хавсралтын 1.4 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Таван толгойн талаар Улсын Их Хурлаас баталсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Таван толгойн орд газраас олборлож байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулан, нэмүү өртөг шингээж, экспортын нэг цонхны бодлогын хүрээнд олон улсын зах зээлд борлуулах, уг зорилгоор орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байх хувилбараар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор шийдвэрлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл, Ц.Нямдорж,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

21.Тогтоолын төслийн 1.15 дахь дэд заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

22.Тогтоолын төслийн 1.16 дахь дэд заалтыг хавсралтын 3.4 дэх дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Хөрш орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам, хурдны авто зам, нефть, байгалийн хий, эрчим хүчний дэд бүтцийн урсгал бий болгох санал дэвшиүүлж энэ чиглэлээр яриа хэлэлцээг эхлүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

23.Тогтоолын төслийн 1.17 дахь дэд заалтыг хавсралтын 1.7 дахь дэд заалт болгон “бууруулж” гэсний дараа “иргэний агаарын тээврийг дэмжих зэргээр аялал жуулчлалын хатуу болон зөөлөн дэд бүтцийг сайжруулах,” гэж нэмэх, “зугаалгын, төвүүдийн, зарим” гэснийг “зугаалга, бизнес төв, татваргүй худалдааны” гэж өөрчлөх “хөхиулэн”, “хязгаарлагдмал хүрээнд” гэснийг тус тус хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

24.Тогтоолын төслийн 1.18 дахь дэд заалтыг хавсралтын 1.5 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах хүрээнд төмөр замын цариг, тээврийн бусад дэд бүтцийг шийдвэрлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

25.Тогтоолын төслийн 1.19 дэх дэд заалтыг хавсралтын 4.2 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд түлш, эрчим хүчний үнэ, тарифыг чөлөөлж, тус салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон дамжуулах шугамыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар барьж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх ”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

26.Тогтоолын төслийн 1.20 дахь дэд заалтыг хавсралтын 4.3 дахь дэд заалт болгон “хөтөлбөр” гэснийг “тэдгээрийн удирдлагыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд шилжүүлэх хөтөлбөрийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

27.Тогтоолын төслийн 1.21 дэх дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

28.Тогтоолын төслийн 1.22 дахь дэд заалтыг хавсралтын 2.6 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дарамт учруулсан, давхацсан хяналт шалгалтыг хийхгүй байх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

29.Тогтоолын төслийн 1.23 дахь дэд заалтыг хавсралтын 1.8 дахь дэд заалт болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“Гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, жуулчдад визийн дэглэмийг тааламжтай болгох, гадаадын улс орнуудаас хөрөнгө босгох сонирхол бүхий аж ахуйн нэгжүүдийг төлөөлөх эрх бүхий этгээдэд гадаад улсуудад визгүй зорчих боломжийг олгон албан паспорт олгох журам бий болгох ”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, С.Бямбацогт, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Ц.Нямдорж, А.Тлейхан Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар,
Л.Энх-Амгалан

30.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.1 дэх дэд заалт нэмэх:

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг доор дурдсан чиглэлээр боловсруулж, өргөн мэдүүлэх:

- төсвийн урсгал зардлыг бууруулж, хэмнэлтийн горимд шилжих;
- улсын төсөвт ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн тооцох;
- хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахгүй байх;

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, тогтолцоог боловсронгуй болгох; ”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

31.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.3 дахь дэд заалт нэмэх:

“Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд Оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг түргэтгэх, уг төслийн хэрэгжилтэд Улсын Их Хурал, Засгийн газраас бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

32.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.6 дахь дэд заалт нэмэх:

“Таван толгой-Гашуунсухайт-Нарийнсухайт-Шивээхүрэнгийн төмөр зам болон тээврийн бусад дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар барьж байгуулах”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

33.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 2.2 дахь дэд заалт нэмэх:

“Бизнесийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, далд эдийн засгийг бууруулах, татварын бааз, суурийг өргөтгөх чиглэлээр Эдийн засгийн өршөөлийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

34.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 2.3 дахь дэд заалт нэмэх:

“Өмчлөх эрхийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

35.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 2.4 дэд дэд заалт нэмэх:

“Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, тусгай зөвшөөрлийн тоог эрс цөөлөх чиглэлээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

36.Тогооолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 2.7 дахь дэд заалт нэмэх:

“Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

37.Тогооолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 3.2 дахь дэд заалт нэмэх:

“Бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

38.Тогооолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 4.4 дэх дэд заалт нэмэх:

“Уламжлалт бус газрын тос, нүүрс шингэрүүлэх, хийжүүлэх, эрчим хүч экспортлох төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд бодлогын дэмжлэг үзүүлэх” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

39.Тогооолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 3.5 дахь дэд заалт нэмэх:

“Соёл, урлаг, спортын салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах” гэж нэмэх

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан

Хоёр.Байнгын хорооны дэмжээгүй санал

1.Тогтоолын төслийн хавсралтад “Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийж 2014 оны 06 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулан цаашид уг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

2.Тогтоолын төслийн хавсралтад “Монгол Улсын нэгдсэн төсвөөс гадуур хяналтгүй зарцуулагдаж байгаа Чингис болон Самурай бонд, Хөгжлийн банкны зээлийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн төсөвт тусгах” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

3.Тогтоолын төслийн хавсралтад “Бондын өрийг 2017 оноос төлж эхлэх тул төсвийн тодотголд төлөх өрийн 1/3 хувийг бүрдүүлэх эх үүсвэрийг тусгаж нөөц сан бүрдүүлэх” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

4.Тогтоолын төслийн хавсралтад “Бага, дунд орлоготой иргэдэд хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх” гэж нэмэх.

**Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

5.Тогтоолын төслийн хавсралтад “Цалин, тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх” гэж нэмэх.

**Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

6.Тогтоолын төслийн хавсралтад “Чингис бондын хуваарилагдаагүй болон зарцуулагдаагүй хөрөнгийн эх үүсвэрийг бодитой үйлдвэрлэлд хөрөнгө оруулах буюу үйл ажиллагаа нь жигдэrsэн экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл

явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж нэмэх.

**Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
А.Тлейхан, Л.Энх-Амгалан
Цөөнх:Дээр дурдсан гишүүд**

7.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх арга хэмжээнд “төсвийн хөрөнгийн урсгал зардлыг 20 хувиар бууруулах” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар
Цөөнх:Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар**

8.Тогтоолын төслийн хавсралтад “Төрийн байгууллага, албан тушаалтан баяр, ойн арга хэмжээ, дайллага, хүлээн авалт, бэлэг дурсгалд төсвийн хөрөнгөөс гаргахыг хориглоно.” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар

9.Тогтоолын төслийн хавсралтад “Төсвийн хөрөнгөөр хэвлэл, мэдээлэлд сурталчилгаа хийх, хаалтын гэрээ хийхийг хориглоно.” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар

10.Тогтоолын төслийн хавсралтад “Татвар төлөгчид, төрийн бус байгууллагаас төсвийн хөрөнгийн зарцуулалтаар хяналт тавих, шалгалт хийх”, “Төсвийн зарцуулалтыг хамт олондоо мэдээлэх, хэвлэлд тайлангаа мэдээлж байх” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар

11.Тогтоолын төслийн хавсралтад “Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг төр ба хувийн хэвшлийн эрх үүргийн тэнцвэр, санхүүжилт, төлбөр, тооцооны хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

12.Тогтоолын төслийн хавсралтад “Ядуурлын олон хүчин зүйлээс хамааралт байдал, архаг шинж чанартай болж байгаад дүгнэлт хийж, Өрхийн амьжиргааг дэмжих үндэсний хөтөлбөрт тэтгэвэр, тэтгэмж, халамжийн тогтолцоонд олон улсын туршлагын дагуу нөхцөлт мөнгөн шилжүүлгийн зарчим, арга хэрэгслийг нэвтрүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

13.Тогтоолын төслийн хавсралтад “Цалингийн болон тэтгэврийн зээлийн нөхцөлүүдийг хүртээмжтэй санхүүжилтийн зарчмаар зөөлрүүлэх, иргэдийн

амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлөхгүй байх чиглэлээр Засгийн газар, Монголбанк хамтран ажиллах арилжааны банкуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээ нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

Гурав. Найруулгын санал

1. Тогтоолын төслийн 2 дахь заалтыг 4 дэх заалт болгох.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Г.Батхүү,
М.Батчимэг, Б.Гарамгайбаатар, С.Дэмбэрэл,
Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан**

--ooОOoo--